



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/153

Эрдэнэт


### Хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2./г/, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, 78.2.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 157 дугаар тогтоол тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах журам"-ын 5.6 дахь заалтын дагуу албан ажлын шаардлагыг харгалзан 657.876.199 төгрөгийн анхны үнэтэй, 10.536.826 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл, 647.339.373 төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий Дэнж багт байрлалтай 40 ортой эмнэлэгийн барилгыг БОЭТ-ийн балансаас хасч, ЭМГ-ын балансад шилжүүлэхийг Орон нутгийн өмчийн газарт /н.Оюунгэрэл/-т зөвшөөрсүгэй.

2. Дээрх хөрөнгийг актаар хүлээлцэж санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн бүртгэлд зохих журмын дагуу өөрчлөлт оруулахыг холбогдох байгууллагын дарга, нягтлан бодогч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc

02000 0770